




## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗЭЭЛ ТУСЛАМЖ АВСАН АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДИЙН 34 ХУВИЙН ХӨРӨНГИЙН  
АШИГЛАЛТ САЙН БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН  
ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ

АУДИТЫН КОД: ОРА-2023/25-13-ШТА-ГА



Орхон аймаг  
2023 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

**Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор  
Ц.Нармандах**

Утас: 70353888 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

**Аудитын менежер Б.Буян-Ундрах**

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

**Ахлах аудитор Т.Болормаа**

Утас: 70357955 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

**Аудитор О.Гантуяа**

Утас: 70355805 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn

**Аудитор Ж.Наранчимэг**

Утас: 70359826 Цахим хаяг: naranchimegj@audit.gov.mn



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 08 сарын 18 өдөр

Дугаар A/12

Эрдэнэт

Аудитын тайланг баталгаажуулах  
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүрэг"-ийн 2.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, Баян-Өндөр сумын Засаг дарга, Жаргалант сумын Засаг дарга, Хүнс, Хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг холбогдох төсвийн захирагчдаар арилгуулах, өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Батжаргал/-д зөвлөсүгэй.
4. Аудитын тайлангаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Б.Буян-Ундрах/, ахлах аудитор /Т.Болормаа/, аудитор /О.Гантуяа, Ж.Наранчимэг/ нарт даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ

D:\my doc \bichig heregl\ tushaal\2023.doc

**АГУУЛГА**

|                               |   |
|-------------------------------|---|
| Товчилсон үгийн тайлбар ..... | 3 |
| Хүснэгтийн товъёг .....       | 3 |
| Ерөнхий мэдээлэл.....         | 5 |

**Нэг. ОРХОН АЙМАГТ ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР ОЛГОГДСОН БАТЛАН ДААЛТЫН САН БОЛОН БНБУ-ЫН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛЭЭС АЖЛЫН БАЙР НЭМЭГДЭЭГҮЙ БАЙНА.....7**

|                                                                                                                                              |   |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|
| A.2. Зээл авсан иргэн, аж ахуйн нэгжүүд зээлийн гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэн ажилласан хэдий ч шинээр ажлын байр нэмэгдээгүй байна..... | 7 |
| A.2.1. Хөдөө аж ахуйн зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжүүд зээлийн гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.....                  | 7 |
| A.2.2. Бага орлоготой иргэн, аж ахуйн нэгжид зээл олгосон нь ажлын байрыг нэмэгдүүлээгүй байна.....                                          | 9 |

**Хоёр. ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨ САЛБАРЫН БОДЛОГОТОЙ УЯЛДАЖ БАЙГАА Ч ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ БҮРЭН ХАНГАГДАХГҮЙ БАЙНА.....15**

|                                                                                                                                     |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| B.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдаж байна.....                                    | 15 |
| B.1.1. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь урт, дунд, богино хугацааны бодлогыг дэмжиж байна.....                | 15 |
| B.1.2. Тусламж нь нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан хөрөнгө оруулалт боловч ашиглалтгүй, үр өгөөжгүй хөрөнгө байсаар байна..... | 16 |
| B.2 Төслийг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг орон нутагт үнэлж дүгнэдэггүй байна.....                                                     | 22 |
| B.2.1. Засгийн газрын тогтоолд тусгагдсан төлөвлөх, зарцуулах, тайлагнах ажлууд орон нутагт хийгддэггүй байна.....                  | 22 |
| B.2.2. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг үнэлсэн ч төсөлд оролцогч нарт мэдээлдэггүй байна.....       | 23 |

**ГУРАВ. ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ОРОН НУТАГТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА. ....23**

|                                                                                                                                                                   |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| V.1. Зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн явцад харьяа яам хяналт хэрэгжүүлдэг бол орон нутгийн байгууллагын оролцоо байхгүй байна.....               | 23 |
| V.1.1. Орон нутагт төслийг хэрэгжүүлэгч иргэн аж ахуйн нэгж байгаа учраас шилэн дансны цахим сайтад зээл, тусламжтай холбоотой мэдээллийг мэдээлдэггүй байна..... | 23 |
| V.1.2. Орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөр хэрэгжилтийг орон нутгийн байгууллагууд хянадаггүй байна.....                                                      | 23 |
| V.2 Хөрөнгийн ашиглалтын үр дүнг тооцож, төсөлд оролцогч нарыг мэдээллээр хангаагүй байна.....                                                                    | 24 |
| V.2.1 ТХН-ээс жилд 1-2 удаа ирж хяналт хэрэгжүүлсэн ч үр дүнг тооцсон мэдээ, мэдээллээр төсөл хэрэгжүүлэгч нарыг хангаж ажиллаагүй байна.....                     | 25 |
| V.2.2. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга, хэмжээний үр дүнд бий болсон эд хөрөнгийг зарим байгууллага бүртгэлд тусгаагүй байна.....            | 26 |
| Холбогдох байгууллагын санал.....                                                                                                                                 | 27 |
| ДҮГНЭЛТ:.....                                                                                                                                                     | 28 |
| ЗӨВЛӨМЖ.....                                                                                                                                                      | 28 |
| САНАЛ:.....                                                                                                                                                       | 28 |

## ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

| № | Тайлбар                                                                                                  | Хуудасны дугаар |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|
| 1 | Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа буцалтгүй тусламж, техник тусалцаа, хөнгөлөлттэй зээлийн мэдээлэл | 5               |
| 2 | Төслийн мэдээлэл                                                                                         | 7               |
| 3 | Зээлийн мэдээлэл /2023-05-30-ны өдрийн байдлаарх үлдэгдэл/                                               | 8               |

## Товчилсон үгийн тайлбар

|         |                                               |
|---------|-----------------------------------------------|
| УИХ     | Улсын их хурал                                |
| МУЕА    | Монгол Улсын Ерөнхий Аудитор                  |
| АДБОУС  | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| ХАА     | Хөдөө аж ахуй                                 |
| БНБУ    | Бүгд Найрамдах Беларусь Улс                   |
| ТХН     | Төсөл хэрэгжүүлэгч нэгж                       |
| ХШҮ     | Хяналт шинжилгээ үнэлгээ                      |
| ТУХ     | Төслийн удирдах хороо                         |
| ХХААХҮЯ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам    |
| НҮБ     | Нэгдсэн үндэсний байгууллага                  |
| ЗГ      | Засгийн газар                                 |
| ХХК     | Хязгаарлагдмал хариуцлагатай компани          |
| ХААДС   | Хөдөө аж ахуйг дэмжих сан                     |
| АХБ     | Азийн хөгжлийн банк                           |

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

|                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|-------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>     | Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 09 дүгээр тогтоол, МУЕА-ын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| <b>Аудитын зорилт</b>                     | <p>“Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдвээр улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн.</p> <p>Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх;</li> <li>- Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх;</li> <li>- Зээл тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх</li> </ul> |
| <b>Аудитын хамарсан хүрээ</b>             | Аудитад Орхон аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүд болон төслийн удирдах хороо, төслийн нэгж, хэрэгжүүлэгч холбогдох байгууллагын 2016-2022 оны үйл ажиллагааг хамрууллаа.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| <b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b> | Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020, 6817-5:2020, “Гүйцэтгэлийн аудитын зарчим” MNS 6817-7:2020, Гүйцэтгэлийн аудитын стандарт, МУЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, тодруулга, судалгаа авч, шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын асуудлын шинжилгээ, аудитын загварын матриц, аудитын горимыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.                                                                                            |
| <b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b>       | <p>Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого зэргийг үзүүлэлт болгон ашигласан.</p> <p>Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Болормаа, аудитор О.Гантуяа, Ж.Наранчимэг нар 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.</p>                                                                                                                                               |
| <b>Аудитын явцад учирсан хүндрэл,</b>     | Хэрэгжсэн төсөл арга хэмжээний төслийн газар болон зохицуулагчид нь орон нутагт байхгүй, Улаанбаатар хотод төв нь                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |

**бэрхшээлүүд:** байрладаг тул төслийн мэдээлэл авахад хүндрэлтэй байсан.

### Ерөнхий мэдээлэл

Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт Дэлхийн банкны 2, Азийн хөгжлийн банк, Японы ядуурлыг бууруулах сангийн 3, НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн 1, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын санхүүжилтээр нийт 276.6 сая ам.долларын төсөвт өртөгтэй хөнгөлөлтэй зээл болон буцалтгүй тусламжийн хэлбэрээр 12 төслийг Удирдах хороо болон төсөл хэрэгжүүлэх нэгжүүд хариуцан хэрэгжүүлж байна.

Үүнээс Орхон аймгийн хэмжээнд 2016-2027 онд хэрэгжих 150.0 сая ам.долларын төсөвт өртөгтэй хөнгөлөлттэй зээл болон 2 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хэлбэрээр 4 төсөл хэрэгжүүлж байна. Тухайлбал:

Орхон аймагт Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төслөөр “Үржих Таван эрдэнэ” ХХК, 3 иргэний нийт 279.0 сая төгрөгийн зээл олгосноос 2022 оны байдлаар 2 зээл хаагдаж, 2 зээл хэрэгжиж байна.

Хүснэгт 1: Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа буцалтгүй тусламж, техник туслалцаа, хөнгөлөлттэй зээлийн мэдээлэл

| Төслийн нэр, санхүүжүүлэгч                                                                               | Хугацаа, зээлийн дүн                                                          | Зорилго                                                                                                                                                                                                                                                    | Байршил                                                                                                                            |
|----------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл /АХБ, Японы ядуурлыг бууруулах сан/         | <b>2020-2027 он</b><br>Зээл 40.0 сая ам.доллар,<br>Тусламж: 2.0 сая ам.доллар | Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, техник технологийг нэвтрүүлж, хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэн ногоочид, тариаланчдын чадавх, орлогыг нэмэгдүүлэх, хүнсний хангамжийг сайжруулах | Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Завхан, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дархан-Уул, Увс Орхон, Сэлэнгэ, Дорнод Өмнөговь аймаг, Улаанбаатар хот |
| Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төсөл  | <b>2016-2023 он</b><br>60.0 сая ам. доллар                                    | Эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох                                                                                                                                                                                                          | Улаанбаатар хот, 21 аймаг                                                                                                          |
| “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төсөл /АХБ, Японы ядуурлыг бууруулах сан/  | <b>2016-2021 он</b><br>Зээл 50.0 сая ам.доллар<br>Тусламж: 2.0 сая ам.доллар  | Агробизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулах замаар хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах                                                                  | Архангай, Говь-Сүмбэр, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Завхан, Сэлэнгэ, Төв, Ховд, Хэнтий, Хөвсгөл аймаг, Улаанбаатар хот           |
| “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн эргэн төлөлтийн эх үүсвэрээр /АХБ/ | <b>2021-2024 он</b><br>47.4 тэрбум төгрөг                                     |                                                                                                                                                                                                                                                            | Улаанбаатар хот, 21 аймаг                                                                                                          |

Азийн хөгжлийн банк болон Жайка Уур амьсгалын ногоон сан, Даян Дэлхийн байгаль Хамгаалах Сан, Европын Холбоо зэрэг санхүүжүүлэгч байгууллагын зээл тусламжаар 8 төсөл, арга хэмжээг 2019-2027 онд хэрэгжүүлэхээр баталжээ. Үүнд:

- Төрийн болон хувийн хэвшлийн малын эмч нарын практик ур чадварыг бэхжүүлэх төсөл
- Хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөөний төсөл
- ТТ 6584 МОН – Ковид 19-ийн Хямралын Үе дэх Монгол Улсын Хүнсний Аюулгүй Байдлын Эрсдэлийн Удирдлага
- ТТ 9887 МОН – Тэжээлийн Тогтвортой Менежмент
- Хоршоодод суурилсан хөдөө аж ахуйн түүхий эдийн тогтвортой хангамжийн төсөл
- Тогтвортой Хөдөө аж ахуй төсөл
- “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь”
- Монгол Улсад ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төслүүд байна.

Азийн хөгжлийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын 2019 оны “Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээр”, ОХУ-ын Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Дээрх төсөл арга хэмжээг ХХААХҮЯ, Орхон аймгийн 2 сумын ЗДТГ болон холбогдох бусад байгууллагууд 2016 оноос хойш хэрэгжүүлсэн байна.

**НЭГ. ОРХОН АЙМАГТ ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР ОЛГОГДСОН БАТЛАН ДААЛТЫН САН БОЛОН БНБУ-ЫН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛЭЭС АЖЛЫН БАЙР НЭМЭГДЭЭГҮЙ БАЙНА.**

**А.2. Зээл авсан иргэн, аж ахуйн нэгжүүд зээлийн гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэн ажилласан хэдий ч шинээр ажлын байр нэмэгдээгүй байна.**

**А.2.1. Хөдөө аж ахуйн зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжүүд зээлийн гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.**

Азийн хөгжлийн банкны эх үүсвэртэй Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх төслөөс Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй 1 аж ахуйн нэгжид мах, махан бүтээгдэхүүний чиглэлээр 37.0 сая төгрөг, 3 иргэнд үнээ худалдан авах, гахайн аж ахуй өргөтгөх, арьс ширний үйлдвэрт тоног төхөөрөмж авах зориулалтаар нийт 279.0 сая төгрөгийг олгосон байна.

Үүнээс 1 аж ахуйн нэгж, 1 иргэн 2022 оны 05 дугаар сард зээлийг бүрэн төлсөн байна.

Харин 2 иргэний зээл 2028, 2029 онд төлж дуусах бөгөөд төсөл хэрэгжиж байна.

**Хүснэгт №2**

**Төслийн мэдээлэл**

**/сая.төгрөг/**

| № | Төслийн нэр                               | Зээлийн огноо | Зээлийн мөнгөн дүн | Зээлийн хугацаа |
|---|-------------------------------------------|---------------|--------------------|-----------------|
| 1 | Мах махан бүтээгдэхүүний тоног төхөөрөмж  | 2018-02-15    | 37.0               | 5 жил           |
| 2 | Үнээ худалдан авах                        | 2018-02-15    | 42.0               | 5 жил           |
| 3 | Гахайн аж ахуй өргөтгөх                   | 2018-07-02    | 100.0              | 10 жил          |
| 4 | Арьс ширний үйлдвэрт тоног төхөөрөмж авах | 2019-04-15    | 100.0              | 10 жил          |
| 5 | Нийт дүн                                  |               | 279.0              |                 |

Азийн хөгжлийн банкны эх үүсвэртэй Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх төслөөс зээлд хамрагдсан дээрх 3 иргэн, аж ахуйн нэгж нь Батлан даалтын сан болон банктai гуравласан гэрээ байгуулдаг бөгөөд гэрээнд оролцогч талуудын үүргийг зээл олгосон банк хангуулан ажиллаж байна.

Батлан даалтын гуравласан гэрээний 3.6.7-д “өөрийн нэр хаяг, утасны дугаар, үйл ажиллагааны чиглэл, өмчийн харьяалал, дансны мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд энэ тухай ажлын 3 /гурав/ хоногт багтааж Банк болон ЗБДС-нд албан ёсоор мэдэгдэх” гэж заасны дагуу 1 иргэн гахайн аж ахуй өргөтгөх зориулалтаар зээл авч гахайн мялзан өвчнөөс шалтгаалж зээлийн зориулалтыг өөрчлөн газар тариалан болгох талаар банкны ажилтнуудад тухай бүр мэдэгдсэн байсан.

Мөн Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн төслөөс “Эрдмийт” ХХК 2,200.0 сая төгрөг, “Эрдэнэт Мах Маркет” ХХК 5,390.3 сая төгрөг, “Натурал Техстайл Групп” ХХК 7,200.0 сая төгрөг, “Жүр үр” ХХК 1,600.0 сая төгрөг нийт 16,390.3 сая төгрөгийн зээлийг тус тус авсан байна.

Зээлийн мэдээлэл 2023-05-30-ны өдрийн байдлаарх үлдэгдэл

Хүснэгт №3

/сая.төгрөг/

| № | Зээлдэгчийн нэр            | Зээлийн дүн | Зээл авсан огноо | зээлийн үлдэгдэл |
|---|----------------------------|-------------|------------------|------------------|
| 1 | Эрдмийт ХХК                | 2,200.0     | 2019-05-03       | 1,272.0          |
| 2 | Эрдэнэт мах маркет ХХК     | 5,390.3     | 2020-02-12       | 4,491.9          |
| 3 | Натурал техстайл групп ХХК | 7,200.0     | 2019-05-03       | 4,440.0          |
| 4 | Жүр үр ХХК                 | 1,600.0     | 2019-09-04       | 1,333.3          |
|   | Нийт дүн                   | 16,390.3    |                  | 11,537.2         |

Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд ХААДС-тай трактор, хөдөө аж ахуйн техник худалдах, худалдан авах гэрээ байгуулан Орхон аймгийн “Бүрэн дөхөм” ХХК, 1 иргэн тус бүр беларусь-82.1 трактор, хадуур-КДН210, тармуур-ГВР 630, дөрвөлжин хамаг боогч-ППТ160 нийт 33,920 еврогийн 4 тоног төхөөрөмжийг урьдчилгаа төлбөрт 10,176 еврог төлж, үлдэгдэл 23,744 еврог 3 жилийн хугацаанд 3 тэнцүү хуваан төлөхөөр зээл авсан байна.

Зээлийн эргэн төлөлт 2023 оны байдлаар “Бүрэн дөхөм” ХХК 8,501.2 еврог төлж, үлдэгдэл 15,568 евро, 1 иргэн 16,309.6 еврог төлж, үлдэгдэл 7,759 евро байгаа ба зээлийн хугацаа 2024 онд дуусахаар байна.

Орхон аймгийн хэмжээнд Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээс авсан 4 иргэн аж ахуйн нэгжийн 279.0 сая төгрөгийн зээл жилийн 12% хүүтэй, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилтээс авсан 4 аж ахуйн нэгжийн 16,390.3 сая төгрөгийн зээл жилийн 8% хүүтэй, БНБУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 2 иргэн аж ахуйн нэгжийн 67,840 еврогийн зээл жилийн 1.37% хүүтэй ба 3-10 жилийн хугацаатай авсан байна.

2023 оны 7 дугаар сарын байдлаар зээлийн төлөлт бүрэн дууссан 2 иргэн, аж ахуйн нэгж, зээлээ графикайн дагуу төлж буй 8 иргэн, аж ахуйн нэгж байна.

### А.2.2. Бага орлоготой иргэн, аж ахуйн нэгжид зээл олгосон нь ажлын байрыг нэмэгдүүлээгүй байна.

Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор 1 аж ахуйн нэгж, 4 иргэнд 18 ажлын байр бий болгох зорилгоор зээл олгосон ч шинээр ажлын байрыг бий болгоогүй байна. Зээлийн ашиглалтыг үзэхэд:

Үнээ худалдан авах зориулалтаар 42.0 сая төгрөгийн зээл авсан иргэнтэй холбоо барих боломжгүй, Дархан-Уул аймагт шилжсэн талаар мэдэгдсэн тул Монгол банкны ажилтан, зээлийн даалтын сан хариуцсан мэргэжилтнээс банкны ажилтнуудын хийсэн эргэн хяналтын тайланг авч үзсэн болно.




Тус тайланд зээлдэгч нь зээлийн хөрөнгөөр “Шим дүүрэн сааль” ХХК-ийн үйл ажиллагааг өргөжүүлэх зориулалтаар Төв аймгийн Борнуур сумаас сайн үүлдрийн сүүний чиглэлийн 20 үнээ, 1 бух худалдан авахад зарцуулсан бөгөөд зээлдэгчийн фермерийн үйл ажиллагаа хэвийн, зээлээ хуваарийн дагуу 2022 оны 05 сард бүрэн барагдуулсан байна.

“Үржих таван эрдэнэ” ХХК нь зээлийн батлан даалтын сангаас мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор 37,000.0 мянган төгрөгийн зээлийг 2018 оны 02 дугаар сард 5 жилийн хугацаатай авсан бөгөөд зээлийн эх үүсвэрээр махан бүтээгдэхүүн хийх ангилах, махан таташ хийх тоног төхөөрөмж худалдан авч, мах нөөцлөх, ангилах, махан таташ хийх үйл ажиллагаа эрхэлж байна.





Гахайн аж ахуйн өргөтгөл хийх зорилгоор 2019 оны 07 дугаар сард 100.0 сая төгрөгийн зээл авсан 1 иргэний хувьд гахайн мялзан өвчин гарсны улмаас гахайг устгаж, гахайн аж ахуйн үйл ажиллагааг 3 жил хориглосон тул зориулалтаа өөрчилж газар тариалангийн талбай эрхлэх хүсэлтээ зээл авсан банканд өгч, газар тариалангийн тоног төхөөрөмж худалдан авч будаа тариалж байна.



Арьс ширний үйлдвэрт тоног төхөөрөмж авахаар 100.0 сая төгрөгийн зээл авсан 1 иргэн тоног төхөөрөмж авсан эсэх нь тодорхойгүй, аудитын явцад удаа дараа холбогдож зээлийн зарцуулалттай танилцахыг хүссэн боловч орон нутагт ноос худалдан авч байгаа гэсэн тайлбар өгч, ирж уулзаагүй тул батлан даалтын сангийн мэргэжилтнээс банкны эргэн хяналтын тайланг авч үзсэн.

Эргэн хяналтын тайланг үзэхэд зээлдэгч нь 100.0 сая төгрөгийг 10 жилийн хугацаатай авснаас 50.0 сая төгрөгийг өмнөх хөрөнгө оруулалтын зээл хаахад, 30.0 сая төгрөгийг тоног төхөөрөмж, 19.2 сая төгрөгийг эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрт зарцуулж, зээлээ графикийн дагуу төлж байна гэж тайлагнасан.

Батлан даалтын сангаас 4 иргэн аж ахуйн нэгжид олгосон 279.0 сая төгрөгийн зээл нь өрхийн амьжиргааг нэмэгдүүлсэн.

Зээлийн эх үүсвэрээс 1 иргэн өмнө нь авсан хөрөнгө оруулалтын зээлийн үлдэгдлээ барагдуулсан, 1 иргэн нь саалийн үнээ худалдан авч сүүгээ худалдан борлуулахад өөр хүн хүч шаардлагагүй, 1 иргэн нь газар тариалангаа өөрсдөө тариалж ургацаа хураадаг, 1 аж ахуйн нэгж нь тоног төхөөрөмж авсан ч хуучин ажиллах хүчний нөөц бололцоогоор ажиллаж байгаа зэргээс шалтгаалж шинэ ажлын байрыг бий болгоогүй байна.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилтийн төслөөс “Эрдмийт” ХХК мах махан бүтээгдэхүүн, “Эрдэнэт Мах Маркет” ХХК мах махан бүтээгдэхүүн, “Натурал Текстайл Групп” ХХК ноос ноолуур, Жүр үр ХХК нь сүүний үйлдвэр барихаар тус бүр зээл авсан.

Үүнээс Жүр үр ХХК нь 2019 оны 11 дүгээр сард 1,600.0 сая төгрөгийн зээлийг 7 жилийн хугацаатай, жилийн 8%-ийн хүүтэй авч сүүний үйлдвэрийг Эрдэнэт хотод байгуулахаар төлөвлөсөн. Үйлдвэрлэлийн зориулалттай 1629 кв.м газар худалдан авч барилгын зураг төсвийн ажлууд хийгдэж байсан ч коронавирус /ковид-19/ цар тахлын улмаас төсөл хэрэгжихгүй хойшилсон.

Харин 2022 оноос эхлэн Жүр үр ХХК-ийн удирдлагын багаас хүндрэлтэй цаг үед шинэ томоохон төсөл хэрэгжүүлэх нь төслийн санхүүжилтийг эрсдэлд оруулж болзошгүй гэж дүгнэн үйлдвэр барих, тоног төхөөрөмж худалдан авах ажлуудыг хойшлуулсан бөгөөд төслийн нэгжид төсөл бүрэн хэрэгжээгүй талаар 2 удаа албан бичгээр тайлбар хүргүүлсэн байна.


Аудитын явцад төслийн хэрэгжилттэй танилцах гэсэн боловч Орхон аймагт төсөлтэй холбоотой анхан шатны баримт материал болон баригдсан барилга байгууламж, шинэ бий болсон үйлдвэрлэл зэрэг төслийн гүйцэтгэл хангагдаагүй, хэрэгжээгүй байсан тул зээлийн үлдэгдэл төлбөр 1,333.3 сая төгрөгийг 2023 оны 07 дугаар сарын 22-оос 24-ны хооронд бүрэн төлүүлж барагдуулсан.

Натурал Текстайл Групп ХХК нь ноос ноолуурын чиглэлээр буюу түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, эсгий гутлын цех байгуулж, шинэ ажлын байр нэмэгдүүлэх, нэрийн дэлгүүрийн тоог нэмэх, экспортын борлуулалтыг өсгөх, шаардлагатай засваруудыг хийхэд 9,000.0 сая төгрөгийн төсөл бичиж, төслийн нэгж нь бизнес, санхүү, нийгэм жендер, байгаль орчны гэсэн 4 төрлийн үнэлгээг хийж АХБ-д хүргүүлэн хянагдсанаар төслийн удирдах хорооны 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар 7,200.0 сая төгрөгийн зээлийг АХБ-ны эх үүсвэрээр, 1,800.0 сая төгрөгийг өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шийдвэр гарсан.

Зээлийн санхүүжилтийг Натурал Текстайл Групп ХХК-ын дансанд 2 удаагийн шилжүүлгээр буюу 2019 оны 06 сарын 12-ны өдөр 6,950.0 сая төгрөг, 08 дугаар сарын 14-ний өдөр 250.0 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн. Төслийн зээлээр дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- Эсгий гутлын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, эсгий гутлын зориулалттай улны шинэ загварын хэв хийлгэж, “Van de wiele” нэхэх машины техник, технологийг шинэчилж, түүхий эдийг үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулж хангалттай хэмжээнд бэлтгэсэн.
- Зураг, загварын нарийвчлалыг нэмэгдүүлэх, загварын алдааг хянах, загварыг хөгжүүлэхэд зураачидтай хамтран ажиллаж, загвар дизайнаа хөгжүүлэх, загварын чиглэл, хэрэглэгчдийн сонголтыг нэмэгдүүлэх зорилгоор шинэ загвар дизайн зохион бүтээх ажлууд хийгдсэн.
- Дээврийн 31000м<sup>2</sup> талбайгаас 20600м<sup>2</sup>-д ашиглалтын хугацаа урт найдвартай материалаар хучилт, дотроос нь хөөсөн дулаалга хийж засварласнаар гүйцэтгэх, нэхэх, ноолуурын цехүүдэд дусаал гоожихгүй болж, дулааны алдагдал буурсан нь үйлдвэрлэл хэвийн явах, ажиллагсдын ажлын орчин сайжрахад нөлөөлсөн.

- Улаанбаатар хотод “Ривер гарден”, “Шангри-ла” худалдааны төвүүдэд нэрийн барааны дэлгүүр шинээр нээсэн.
- Салбар дэлгүүрүүдийн борлуулагч нарыг нэгдсэн журмаар “Борлуулалт ур чадвар”-ын сургалтад хамруулсан.
- Тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж ноос ноолуур угаах, нэхэх тоног төхөөрөмжүүдийг шинээр суурилуулсан.
- Ажилчдын хоолны газарт засвар хийж зай талбай 2 дахин нэмэгдэж, эрүүл ахуй ариун цэврийн шаардлагад нийцсэн байдлаар засварласан.
- Бие засах өрөөнүүдийг нэмж хийснээр, ариун цэврийн өрөөний хангамж эрс сайжирсан байна.



Уг төсөлд хамрагдсанаар Натурал Текстайл Групп ХХК нь 2021 онд анх удаа ээрмэлийн экспорт хийж, Иран улсад 30 тн утас гаргасан бол 2022 онд 120 тн болж өссөн.

Мөн Итали улсад 40 тн самнасан тэмээний ноос экспортолсон бол Япон, Хятад улсуудад эцсийн бүтээгдэхүүнээ экспортолж эхлээд байна.


“Эрдмийт” ХХК нь өөрийн эх үүсвэрээр 500.0 сая төгрөг, зээлийн эх үүсвэрээр 3,000.0 сая төгрөг нийт 3,500.0 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлэхээр байсан боловч төслөөс 2,200.0 сая төгрөг, үлдэгдэл 1,300.0 сая төгрөгийг өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шийдвэр гарсан байна.

Зээлийн хөрөнгөөр үйлдвэрийн шугамыг өргөтгөх, мах ангилан шулах цехийг шинээр барих, үйлдвэрийн байрын агуулахтай холбох түннел барих, бэлэн бүтээгдэхүүн чанах өрөөг барих зэрэг ажлуудыг хийж, лабораторид өрөө тасалгаа хийж тусгаарлалт хийсэн, гадна тоног төхөөрөмжийг шинэчилсэн байна.

Тус үйлдвэр 43 ажилтантай байсан бол төсөлд хамрагдаж засвар шинэчлэл хийгдсэнээр одоо 60 ажилтантай болж, ажлын байр 17 ажилтнаар нэмэгдсэн байна.

Мөн 2022 оноос экспортоо нэмэгдүүлснээр борлуулалтын орлого 2021 онд 5,877.4 сая төгрөг, 2022 онд 9,259.4 сая төгрөг болж өссөн байна.

Уг төсөл нь 7 жилийн хугацаатай, жилийн 8% хүүтэй олгогдож байгаа нь бусад төслөөс харьцангуй урт хугацаатай тул хүндрэл бэрхшээл гарах нь бага, төслийн үр дүнг харах бүрэн боломжтой байдаг тул бусад төслийн зээлээс давуу талтай гэж Эрдмийт ХХК-ийн гүйцэтгэх захирал ярилцлагадаа дурдсан.



“Эрдэнэт мах маркет” ХХК нь төслөөс 5,390.3 сая төгрөгийн зээлийг 8 жилийн хугацаатай, жилийн 8%-ийн хүүтэй авсан бөгөөд эхний 3 жил зээлийн хүүгээ төлж, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, зээлийн хөрөнгөөр мах боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжид шинэчлэл хийсэн.

Төсөлд хамрагдсанаар үйлдвэрлэлийн хэмжээ хүчин чадал нэмэгдэж 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болсноор ажлын байр 2020 онд 41 байсан бол 2022 онд 66 болж, 25 байнгын ажлын байр нэмэгдсэн байна.



Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээр Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилтийн төсөлд хамрагдсан дээрх 4 аж ахуйн нэгж байгууллага нь тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийснээр бүтээгдэхүүний тоо ширхэг, нэр төрөл, экспортын хэмжээ нэмэгдсэн, ажлын байр бий болж борлуулалтын орлого нэмэгдсэн үр дүнгүүд гарсан байна.

Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөгжлийн банкны эх үүсвэртэй Хөдөө аж ахуйг дэмжих сангаас Орхон аймгийн Бүрэн дөхөм ХХК, 1 иргэн тус бүр Беларус-82.1 трактор, хадуур-КДН210, тармуур-ГВР-630, дөрвөлжин хаман боогч-ППТ-160 нийт 33,920.0 еврогийн үнэтэй 4 тоног төхөөрөмж авсан.

Бүрэн дөхөм ХХК нь /РД4373308/ нь анх зээлд хамрагдахдаа Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны 09 дүгээр сарын 30-ны 03/1869 тоот албан бичигт “2020 оноос газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа нь үнэн болохыг тодорхойлов” гэсэн тодорхойлолтыг хавсаргасан боловч Орхон аймагт газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэггүй, улсын бүртгэлийн гэрчилгээнд газар тариалангийн чиглэл

тусгагдаагүй, гадаад, дотоод худалдаа чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байхад төсөлд хамрагдаж трактор, техник хэрэгсэл авсан.

Зээлээр авсан техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтыг үзэхэд Орхон аймагт байхгүй, Төв аймгийн Эрдэнэ сант сумын 4-р бригадад ногоон тэжээл тарих, хадлангийн өвс авахад ашиглаж буй бөгөөд өөрсдийн эзэмшлийн адуу, үхрийн өвс тэжээлийг бэлтгэдэг тул объект дээр ашиглалтыг үзэх боломжгүй байлаа.

Харин 1 иргэн нь зээлд хамрагдахдаа бүрдүүлсэн анхан шатны баримт тодорхойгүй, зөвхөн зээл олгосон зээлийн гэрээний мэдээллийг ҮАГ-аас ирүүлсэн. Зээл авснаас хойш эхний жил ашигласан гэх боловч, одоогоор ашиглалтгүй, өөр хүнд шилжүүлэхээр хүсэлт өгсөн ч албан ёсоор шилжих шийдвэр гараагүй байна.

БНБУ-ын хөгжлийн банк болон Монгол Улсын Засгийн Газрын хооронд байгуулсан гэрээний дагуу хөнгөлөлттэй зээлээр олгогдсон техник тоног төхөөрөмжийн зээлийн эргэн төлөлт хэвийн боловч ашиглалт хангалтгүй, төсөлд хамрагдсанаар гарсан үр дүн байхгүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт болсон байна.

## **ХОЁР.ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨ САЛБАРЫН БОДЛОГОТОЙ УЯЛДАЖ БАЙГАА Ч ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ БҮРЭН ХАНГАГДАХГҮЙ БАЙНА.**

**Б.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдаж байна.**

**Б.1.1. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь урт, дунд, богино хугацааны бодлогыг дэмжиж байна.**

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д тогтвортой хөдөө аж ахуйн хүрээнд 15 зорилт, арга хэмжээ, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 15 зорилт, арга хэмжээ, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 15 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 7 дугаар зүйлийн 2-т эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ гэсэн заалтад 3 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг тайлагнаж ажилласан байна. Үүнд:

1-р зорилтын хүрээнд Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамруулж хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлнэ гэсэн зорилтын хүрээнд 2 арга хэмжээ хэрэгжүүлсэн.

- Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах.
- Бизнес эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлэх.

2-р зорилтын хүрээнд Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ.

- “Эрдэнэт үйлдвэрлэл” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.

- “Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх.

3-р зорилтын хүрээнд Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.

- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг зээлийн бодлогоор дэмжин ажиллах.
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд тохирлын баталгаажуулалтаар дэмжлэг үзүүлэх.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан дээрх 3 зорилтын 6 арга хэмжээний хэрэгжилтийг 90-100 хувийн биелэлттэй үнэлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих замаар дотоодын хэрэгцээгээ жилийн турш тогтвортой хангах зорилго бүхий “Өрхийн тариалалтын дэмжих” хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 10 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг тайлагнасан байна.

Тус хөтөлбөрт 4 зорилт 15 төсөл арга хэмжээ тусгагдсан бөгөөд хэрэгжилтийн тайланд дараах ажлууд хийгдсэн. Үүнд:

1. Жаргалант сум орон нутгийн төсвийн хөрөнгөөр бууц цацагч, эрдэс бордоо цацагч худалдан авч тариаланчдын үйл ажиллагааг дэмжин ажилласан.
2. Улсын төсвийн хөрөнгөөр 60 ширхэг хүлэмж, Орон нутгийн төсвөөс 27 ширхэг хүлэмжийн үнийг 50 хувь хөнгөлөн иргэдэд олгосон.
3. Орон нутгийн төсвөөс 2 сумын Засаг даргын Тамгын газраар дамжуулан төмс болон төл сонгино, өргөст хэмхийн үр, үрсэлгээг 500 өрхөд хуваарилан өгсөн.
4. Улсын төсвийн хөрөнгөөр хүнсний ногооны үрийн үнийг 80 хувь хөнгөлж хуваарилснаас Орхон аймагт 11 төрлийн 410 кг үр, 2 тн төл сонгино, 2 тн төмсний элит үрийг сумдын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгаар дамжуулан 200 өрхөд олгосон талаар дурджээ.

ХХААХҮЯ-ны жилийн ажлын төлөвлөгөөний Газар тариалангийн үйлдвэрлэл хэсгийн 1.1.5-д “Төмс, хүнсний ногооны тариалалт, хураалт болон Монгол ногоо хөтөлбөрийг улсын хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тайлагнах” гэж тусгасан байтал Орхон аймгийн ХХААГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд газар тариалангийн салбарын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнд хүнсний ногооны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хүнсний ногооны тариалах хэмжээг сум бүрт 20 га-аар нэмэгдүүлэх, шинээр газар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах гэж тусгаснаас өөр Монгол ногоо хөтөлбөртэй холбоотой зүйл заалт тусгагдаагүй байна.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зүйл заалтууд, ХХААХҮЯ-ны төлөвлөгөөнд Монгол ногоо хөтөлбөрийн зүйл заалтууд тусгагдсан ч аймгийн ХХААГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

**Б.1.2. Тусламж нь олон нийтэд шаардлагатай хөрөнгө оруулалт боловч хөрөнгийн ашиглалтыг бүрэн хангаагүй байна.**

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслөөр 2022 оны 03 сард Орхон аймгийн Мал эмнэлгийн газарт цахим хурал хийхэд зориулсан 55" инчийн смарт зурагт -1ш, зурагтын босоо хөл-1ш, видео хурлын камер-1ш, чанга яригчтай микрофон-1ш нийт 4,029.5 мянган төгрөгийн 4 нэр төрлийн тоног төхөөрөмж өгсөн байна.

Монгол ногоо-2 хөтөлбөрөөр Орхон аймгийн Баян-өндөр сумын Эко 2 сургууль, 4 цэцэрлэгт 8,705.5 мянган төгрөгийн 9 нэр төрлийн хүлэмж, багаж хэрэгсэл, 5 загвар өрхөд 6,237.5 мянган төгрөгийн 9 нэр төрлийн хүлэмж, багаж хэрэгсэл, 2 жишиг гудамж 41,990.0 мянган төгрөгийн 11 нэр төрлийн худаг, хүлэмж, багаж хэрэгсэл нийт 56,933.0 мянган төгрөгийн хөрөнгийг төслийн хүрээнд өгсөн.

Сургууль, цэцэрлэгүүд Монгол ногоо-2 хөтөлбөрөөс өгсөн хүлэмжид өргөст хэмх, улаан лооль гэх мэт нарийн ногоо, мөн гадна талбайд төмс, лууван, манжин, сонгино, навчит ногоонууд тарьж, өөрсдийн багш ажилчид болон цэцэрлэгийн хүнсний хэрэгцээнд хэрэглэж байна.

Орхон аймгийн 15-р сургууль, 20-р сургууль хөтөлбөрт хамрагдсанаас 15-р сургууль Монгол ногоо хөтөлбөрөөс гадна, тогтвортой хөгжлийн боловсрол-2 төсөлтэй хамтран өвөл зуны 2 хүлэмжид нарийн ногоо тарьснаас гадна, 310 м2 гадна талбайг боловсруулж бөөрөнхий сонгино, төмс тарьсан бол 20-р сургууль ногоо тарьсан боловч ургац аваагүй байдалтай байна.



15-р сургуулийн хүлэмж болон гадаа тариалал



## 20-р сургуулийн хүлэмжид тариалсан ногоо

Монгол ногоо хөтөлбөрт хамрагдсан 4 цэцэрлэг нь хүлэмж болон бусад багаж хэрэгслийг ашиглаж ногоо тарьж байгаа бөгөөд тэдгээрээс 2 цэцэрлэгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй дурдвал:

Говил багт байрлах 2 дугаар цэцэрлэг 16 нэр төрлийн нарийн ногоо тарьж, 3 төрлийн даршилсан бүтээгдэхүүн боловсруулж борлуулснаас 2018 онд 1,121.8 мянган төгрөг, 2019 онд 1,031.6 мянган төгрөгийн ашигтай ажилласан бол 2020 онд 398.3 мянган төгрөг, 2021 онд 593.8 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь 9 нэр төрлийн ногоо тарьж, 3 нэр төрлийн бүтээгдэхүүн борлуулсан нь, өмнөх жилүүдээс ногооны нэр төрөл багассантай холбоотой байна.

2 дугаар цэцэрлэг үлгэр жишээ ажиллаж, албан хаагчид болон эцэг эхчүүд, хүүхдүүдэд нарийн ногооны үрсэлгээ яаж хийх, хүнсний ногоо тарих, тарьсан ногоогоороо ямар хоол хүнс хийх талаар сургалт сурталчилгаа хийж, тарьсан ногоо болон цэцгийн үрсэлгээгээр ашиг орлого олж, ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг бага боловч шийдвэрлэж ажилласан байна.



## 2-р цэцэрлэгийн хүлэмж

Монгол ногоо хөтөлбөрийн сайн хэрэгжүүлж ажилласан тул хөтөлбөрийн нэгжээс ногоо хатаагч, хэрчигч, шүүс шахагч, хатаагчийн тавиур, холигч зэрэг нийт 3,769.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжөөр шагнасан.



## 2-р цэцэрлэгт шагналд өгсөн тоног төхөөрөмж

Монгол ногоо-хөтөлбөртэй хамтран 22 дугаар цэцэрлэгийн багш, ажилчид хүлэмж болон гаднах 165 м<sup>2</sup> талбайд нийт 10 гаруй нэр төрлийн төмс, хүнсний ногоо, нарийн ногоо болон жимсний мод тарьсан.



22-р цэцэрлэгийн хүлэмж болон гадна талбайн тариалалт

Монгол ногоо хөтөлбөрийн загвар өрхөд хамрагдсан 4 өрхийн 1 өрх нь дан мод, гадна талбайн мандлын цэцгийн үрсэлгээ тарьж, борлуулдаг, 1 өрх нь дан нарийн ногоо тарьж борлуулдаг бол 2 өрх нь ямар ч тариалалт хийгээгүй байна.



Даваат багийн Засаг даргын санал болгосноор Ундаргын 17,18 дугаар гудамжийг жишиг гудамж болгож 20 айлын дунд 1 худаг, 4 айлын дунд 1 хүлэмж, гар багаж хэрэгсэл нийт 20,995.0 мянган төгрөгөөр тохижуулж, айл өрхүүд хүлэмжид нарийн ногоо, гадна талбайд төмс хүнсний ногоо тариалж өөрсдийн хүнсний хэрэгцээгээ хангаж байна.

Жишиг гудамжны 20 өрхийн зарим айл өрх нь хүнсний ногоо тарих анхан шатны мэдлэгтэй байхад зарим айл өрх нь мэдлэг, туршлагагүй, анхлан суралцагчид байсныг Монгол ногоо хөтөлбөрийн нэгжээс нарийн ногооны үрсэлгээ хэрхэн хийх, ногоо хэрхэн тарих сургалтыг байнга зохион байгуулж, хэрэгцээт

мэдээлэл болон гарын авлагаар сайн хангаж ажилладаг тухай хөтөлбөрт хамрагдсан айл өрхүүд хэлж байлаа.



Даваат багийн жишиг гудамжны 20 айл өрх

Яргуйт багийн хөтөл хэсэгт зорилтот бүлэгт чиглэсэн жишиг гудмыг бий болгохоор шийдэж, ХХҮГ-аас гаргасан зорилтот бүлгийн 10 өрхийн хашааны банз, хаалгад нийт 11,900.0 мянган төгрөгийг зарцуулсан бол Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр худаг гаргах ажилд 15,000.0 мянган төгрөг, хөтөлбөрөөс 12,000.0 мянган төгрөг, үр шим хүртэгчээс 500.0 мянган төгрөг нийт 27,500.0 мянган төгрөгөөр худаг барих ажлыг санхүүжүүлж үлдсэн 10 өрхөд Баян-Өндөр сумын ажилтнууд орсон.



Яргуйт багийн 20 айл өрх

Орхон аймгийн Баян-Өндөр суманд жишиг гудамж хөтөлбөрт хамрагдсан нийт 40 өрхөөс Даваат багийн 20 өрх Монгол ногоо төслийн зорилгыг хэрэгжүүлж төрөл бүрийн нарийн ногоо, мандлын цэцэг, модны үрсэлгээг тарьж борлуулж байхад Яргуйт багийн 20 өрхөөс 1 өрх хүлэмжийн болон гадна талбайн ногоо тарьж

борлуулдаг бол бусад айлууд эзэнгүй, тогтвор суурьшилтай амьдардаггүй, төслийг зориулалтын дагуу үр дүнтэй ашиглаагүй байна.

Орхон аймгийн Жаргалант суманд 19 иргэнд 17,632.2 мянган төгрөгийн 19 хүлэмж, 7 иргэнд 4,083.3 мянган төгрөгийн хүлэмж, ялтсан халаагч, нийт 21,715.5 мянган төгрөгийн багаж, техник хэрэгслийг төслийн нэгжээс өгсөн байна.

Жаргалант сумын Монгол ногоо төсөлд хамрагдсан байдлыг үзэхэд:



Мөн төслийн нэгжээс Орхон аймгийн Жаргалант сумын салбар хороонд 20,762.9 мянган төгрөгийн 26 нэр төрлийн ногоо даршлах, савлах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг 2019 онд олгосон.



Ногоо даршлах, савлах тоног төхөөрөмжийг Жаргалант сумын ЗДТГ-ын эзэмшлийн байрыг түрээсэлж, байранд засвар тохижилтын ажил хийж үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон ч тогтвортой үйл ажиллагаа явуулж, ажлын байр бий болгоогүй, байрны ашиглалтын зардлыг төлөөгүй учраас сумын

удирдлагаас ажлын байрыг буцааж авах шийдвэрт хүрсэн тул тоног төхөөрөмжүүд ашиглалтгүй, эзэнгүйдсэн байдалтай байна.

Монгол ногоо хөтөлбөрийн нэгжээс Жаргалант сумын салбар хороог урамшуулж тоног төхөөрөмж өгөхдөө орон нутгийн засаг захиргааны байгууллагаар дамжуулалгүй шууд иргэнд өгснөөр нутгийн иргэдэд хүртээмжгүй, ашиглалтгүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт болгох эрсдэлийг бий болгожээ.

Төсөлд хамрагдсанаар дараах үр дүн гарсан. Үүнд:

- Байгууллага өөрийн гэсэн стандарт шаардлага хангахуйц хүлэмж, усалгааны системтэй болсноор жил бүр нарийн ногоо тариалах боломж бүрдсэн.
- Сургууль, цэцэрлэгийн орчинд эко ногоон орчныг бүрдүүлж эко орчныг бүрдүүлэхэд нөлөөлсөн.
- Багш ажилчид хүлэмжийн болон ил талбайд ногоо тариалах мэдлэгтэй болсноор хувийн хүнсний ногооны хэрэгцээг тариалах, цаашлаад худалдан борлуулж амьжиргаагаа нэмэгдүүлэх сонирхол бий болсон.
- Сургууль цэцэрлэгийн орчинд хүнсний ногоо тариалж, хураах ажлыг багш сурагчид хамтран хийснээр хүүхдэд экологийн боловсролыг багаас нь олгож, хөдөлмөрийн үр шимийг мэдрүүлэх, хүнсний ногоог хэрхэн тарьж ургуулж, боловсруулах талаар мэдлэг олгох.

## **Б.2 Төслийг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг орон нутагт үнэлж дүгнэдэггүй байна.**

### **Б.2.1. Засгийн газрын тогтоолд тусгагдсан төлөвлөх, зарцуулах, тайлагнах ажлууд орон нутагт хийгддэггүй байна.**

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх тайлагнах журмын 3.1.11-т “төсөл хэрэгжүүлэх нэгж” (цаашид “ТХН” гэх) гэж төслийг гэрээ, хэлэлцээр болон батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх үүрэг бүхий Төсвийн тухай хуулийн 17.1-д заасан орон тооны нэгжийг”, 3.1.13. “төслийн зохицуулагч” гэж ТХН-ийг удирдах, төслийн хэрэгжилт, үр дүнг хариуцах, энэ журмын 12 дугаар зүйлд заасан үүрэг бүхий этгээдийг (Төсвийн тухай хуулийн 16.4.16-д заасны дагуу) гэж заасан бол Орхон аймагт Монгол ногоо төслийг хэрэгжүүлэх төслийн нэгж, төслийн зохицуулагч байхгүй байна.

Дээрх журмын 2.1.8-д “төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа иргэн, хуулийн этгээд” гэж заасны дагуу Орхон аймгийн 2 суманд 6 аж ахуйн нэгж, 59 иргэн байна.

Мөн журмын 24.3-т “ТХН нь төсөл, арга хэмжээний төсвийн сар, улирал, хагас жил, жилийн эцсийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ТЭЗ-ийн мэдээ, тайланд нэгтгүүлнэ” гэж заасны дагуу төсөлд оролцогч нараас хаварт тариалалтын мэдээ, намарт ургац хураалтын мэдээ авдаг.

Журмын 11.1.2-т “төслийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө (үүнд: сургалт, семинар, гадаад, дотоод томилолт), удирдамж, чиглэлийг тухай бүр батлах” гэсний дагуу орон нутагт төсөлд оролцогч иргэн аж ахуйн нэгжээс сургалтын захиалга өгсний дагуу сургалтыг жилд 2-3 удаагийн давтамжтай зохион байгуулсан байна.

Мөн журмын 18 дугаар зүйл “Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг төлөвлөх”, 19 дүгээр зүйл “Төсөл, арга хэмжээний санхүүгийн удирдлага”, 20 дугаар зүйл “ТХН-ийн үйл ажиллагааны зардал, санхүүжилт”, 21 дүгээр зүйл “Төсөл, арга хэмжээний хүрээнд хийх худалдан авах ажиллагаа”, 24 дүгээр зүйл “Төсөл, арга хэмжээний тайлагналт” гэсэн зүйлд тусгагдсан ажлууд орон нутагт хийгддэггүй байна.

Энэхүү журамд зааснаар төслийн зохицуулагч, төсөл хэрэгжүүлэгч нэгж нь төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлж, төслийг үр ашигтай удирдлагаар хангах, ажлын үр дүнг тооцох, төслийг тайлагнах, мэдээлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой боловч орон нутагт төслийн хэрэгжилтийг өдөр тутамд хэрхэн хянаж, хэрэгжүүлсэн, үр дүнг хэрхэн үнэлж дүгнэсэн зэрэг албан ёсны анхан шатны архивын нэгж байхгүй, төсөлд оролцогч нар энэ талаарх мэдээллээр дутмаг байна.

Фермер эмэгтэйчүүдийн холбоо /ТХН/-той Монгол ногоо хөтөлбөрт оролцогч нь 4 жилийн хугацаатай гэрээ байгуулдаг бөгөөд гэрээний 3.3-т “ил талбайн нэгж талбайгаас 5 кг-аас, хүлэмжийн нэгж талбайгаас 10 кг-аас доошгүй ургац авах чадвартай болж чадавхажсан үедээ дэмжлэгээр авсан тоног төхөөрөмжийг өөрийн эзэмшилд авах эрхтэй”, 3.4-т “тоног төхөөрөмж багаж үр үрслэгийг гэрээнд заасан зориулалтаар нь ашиглах бөгөөд ил талбайн нэгж талбайгаас 3кг-аас, хүлэмжийн нэгж талбайгаас 8 кг-аас доошгүй ургац авах үүрэгтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй оролцогч нарт гэрээгээр заасан үүргээ биелүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй байна.

**Б.2.2. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг үнэлсэн ч төсөлд оролцогч нарт мэдээлдэггүй байна.**

Монгол ногоо хөтөлбөр нь 2016-2020 онд Хүнсний ногооны салбарын тогтвортой хөгжлийг дэмжих, хүйсийн тэгш байдлыг хангах замаар ногоочдын ялангуяа хөдөө орон нутгийн жишиг тариаланчид, хот суурин газрын болон хот орчмын эмзэг бүлгийн өрхүүдийн амьжиргааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой бол 2020-2023 онд хүртээмжтэй, хүйсийн тэгш байдлыг хангасан тогтвортой өсөлтийг хүнсний ногооны салбарт бий болгох замаар иргэдийн амьжиргааг сайжруулах зорилготой 2 үе шаттайгаар хэрэгжсэн.

ХХААХҮЯ-ны хяналт шинжилгээ үнэлгээний тайланд Монгол ногоо хөтөлбөрийн эхний үе шат болох 2016-2020 оны хэрэгжилтийг 80%-тай гэж үнэлснээс төсөлд оролцогч нарыг орон нутгаар нь үнэлж дүгнэсэн тайлан байхгүй байна.

Харин хөтөлбөрийн дараагийн үе шат болох 2020-2023 оны хэрэгжилтийг он оноор тус тусад нь дүгнэсэн бөгөөд 2023 оны хэрэгжилтийг одоогоор дүгнээгүй байна.

Орон нутгийн төсөлд оролцогч 6 аж ахуйн нэгж, 70 иргэнд төслөөс гарсан үр дүнг тооцож, хэрэгжилтийг хэрхэн үнэлсэн мэдээлэл байхгүй байна.

**ГУРАВ. ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ОРОН НУТАГТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.**

**В.1. Зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн явцад харьяа яам хяналт хэрэгжүүлдэг бол орон нутгийн байгууллагын оролцоо байхгүй байна.**

**В.1.1. Орон нутагт төслийг хэрэгжүүлэгч иргэн аж ахуйн нэгж байгаа учраас шилэн дансны цахим сайтад зээл, тусламжтай холбоотой мэдээллийг мэдээлдэггүй байна.**

Орхон аймагт БНБУ-ын эх үүсвэртэй трактор, хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмж нийлүүлэх 67,840 еврогийн зээл, Зээлийн батлан даалтын сангийн 279.0 сая төгрөгийн зээл, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх 4.02 сая төгрөгийн төсөл, Швейцарын хөрөнгө оруулалттай Монгол ногоо хөтөлбөр, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт 16,930.3 сая төгрөгийн төсөл арга хэмжээнүүд хэрэгжиж байна.

Шилэн дансны тухай хуулийн 7.1-т “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” 7.1.1-т “Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан” гэж заасан.

Дээрх төсөл, хөтөлбөрүүд нь Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон арилжааны банк, төслийн нэгжээр дамжуулан хэрэгжиж байгаа бөгөөд орон нутагт зөвхөн төслийг хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжүүд байх тул шилэн дансны цахим сайтад цэс үүсгэж мэдээлдэггүй байна.

**В.1.2. Орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөр хэрэгжилтийг орон нутгийн байгууллагууд хянадаггүй байна.**

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам жил бүр гадаад орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж [mofa.gov.mn](http://mofa.gov.mn) сайтад ил тод мэдээлсэн байна.

Яамны хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн тайланд Монгол ногоо хөтөлбөр, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилтийн төслүүд хамрагдсан бол Зээлийн батлан даалтын сан, БНБУ-ын хөнгөлөлттэй зээлийн ашиглалтад хяналт хэрэгжүүлсэн тайлан сайтад байршаагүй байна.

Хяналт хэрэгжүүлсэн тайлангаас үзэхэд: Монгол ногоо хөтөлбөрийн хэрэгжилтийг 2019 онд 84.9%, 2020 онд 80%-тай, 2021 онд 83.8%, 2022 онд 84.7%-тай үнэлсэн. Хяналт шинжилгээ үнэлгээний тайлангаар 2019 онд 5 зөвлөмж, 2020-2021 онд ижил утга агуулгатай 3 зөвлөмж, 2022 онд 7 зөвлөмж өгсөн байна.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилтийн төслийн хэрэгжилтийг 2020 онд 86.5%, 2021 онд 97.5%, 2022 онд 94%-тай үнэлж, 2021 онд 5 зөвлөмж, 2022 онд 7 зөвлөмжийг төслийн нэгжид өгсөн байна.

Орхон аймагт Монгол ногоо хөтөлбөрийн санхүүжүүлэгч Швейцарын хөгжлийн агентлаг, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт /зээл/-ийн санхүүжүүлэгч Азийн хөгжлийн банкны холбогдох ажилтнууд ирж хэрэгжилтийн явцтай танилцсан байна.

Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байр бий болгох хөтөлбөрийн санхүүжүүлэгч Азийн хөгжлийн банкнаас төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд Орон нутгийн зээлийн батлан даалтын

сангийн мэргэжилтэн /Монгол банкны хяналт шалгалтын байцаагч/ 4 зээлдэгчид хяналт хэрэгжүүлж, зээлийн эргэн төлөлт, зарцуулалтыг хянасан байна.

Орон нутагт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн талаарх мэдээлэл дутмагаас аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар болон сумдын мэргэжилтнүүд хяналт хэрэгжүүлдэггүй, ямар эх үүсвэрээс ямар зээл тусламжид хэн яаж хамрагдсан талаарх мэдээлэл орон нутгийн байгууллагуудад байхгүй байна.

## **В.2 Хөрөнгийн ашиглалтын үр дүнг тооцож, төсөлд оролцогч нарыг мэдээллээр хангаагүй байна.**

### **В.2.1 ТХН-ээс жилд 1-2 удаа ирж хяналт хэрэгжүүлсэн ч үр дүнг тооцсон мэдээ, мэдээллээр төсөлд оролцогч нарыг хангаж ажиллаагүй байна.**

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх тайлагнах журмын 17.1-д “Төсөл хэрэгжүүлэгч байгууллага төслийн хэрэгжилтийг төлөвлөх үе шатанд төслийн ХШҮ-ний ажлын хэсгийг байгуулна” гэж заасан бөгөөд Орхон аймагт төсөл хөтөлбөртэй холбоотой төсөл хэрэгжүүлэгч нэгж байхгүй тул ХШҮ-ний ажлын хэсэг байхгүй байна.

Орон нутагт ТХН байхгүй тул төсөл хөтөлбөрийн ашиглалтад үр дүнг тооцсон эсэх нь тодорхойгүй, ТХН-ээс энэ талаарх мэдээллийг төслийн зохицуулагч болон хамрагдсан иргэн аж ахуйн нэгж байгууллагыг мэдээллээр хангаж ажиллаагүй байна.

Мөн журмын 23.1-т “ТХН-ийн ХШҮ-ний ажилтан төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд улирлын давтамжтайгаар хяналт-шинжилгээ хийж, гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төслийн хяналт-шинжилгээний тайлангийн загвар” маягтын дагуу хяналт-шинжилгээний тайланг боловсруулан Удирдлагын мэдээллийн системд оруулах бөгөөд ТУХ-нд хагас жил тутам танилцуулна” гэж заасан бол орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдэд төслийн нэгжээс жилд 1-2 удаа ирж хяналт хэрэгжүүлж, ажлын явцтай танилцдаг ч төсөлд хамрагдсан иргэдэд хяналт хэрэгжүүлсэн талаарх тайлан бэлтгэж өгөөгүй байна.

### **В.2.2. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга, хэмжээний үр дүнд бий болсон эд хөрөнгийг зарим байгууллага бүртгэлд тусгаагүй байна.**

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслөөр 2022 оны 03 сард Орхон аймгийн Мал эмнэлгийн газарт цахим хурал хийхэд зориулсан 55” инчийн смарт зурагт -1ш, зурагтын босоо хөл-1ш, видео хурлын камер-1ш, чанга яригчтай микрофон-1ш нийт 4,029.5 мянган төгрөгийн 4 нэр төрлийн тоног төхөөрөмжийг Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/21 тоот тушаалаар үндсэн хөрөнгөд орлого авч, санхүүгийн тайланд тусгасан.

Орхон аймагт Бүгд Найрамдах Беларусь улсын засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Бүрэн дөхөм ХХК, иргэн Б.Ариунзул нар хамрагдаж Беларусь-82.1 трактор, хадуур-КДН210, тармуур-ГВР-630, дөрвөлжин хаман боогч-ППТ-160 нийт

33.9 сая төгрөгийн 4 тоног төхөөрөмж авсан. Зээлийн төлбөр төлөгдөж дуусаагүй тул трактор, тоног төхөөрөмж ХААДС-ийн эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй байна.

Монгол ногоо-2 хөтөлбөрөөр Орхон аймгийн Баян-өндөр сумын Эко 2 сургууль, 4 цэцэрлэгт 7,492.5 мянган төгрөгийн 9 нэр төрлийн хүлэмж, багаж хэрэгсэл, шагнал урамшуулалд олгосон 4,769.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийт 12,262.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгахаас 8-р цэцэрлэг 2,187.5 мянган төгрөг, 2-р цэцэрлэг 3,769.9 мянган төгрөг, 15-р сургууль 1,225.0 мянган төгрөгийн хүлэмж, гар багаж, төмсний үрийг бараа материалын орлогод авсан байна.

20 дугаар сургууль 1,270.0 мянган төгрөг, 2 дугаар цэцэрлэг 1,270.0 мянган төгрөг, 22 дугаар цэцэрлэг 1,270.0 мянган төгрөг, 26 дугаар цэцэрлэг 1,270.0 мянган төгрөг нийт 5,080.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй тул 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнах тухай зөвлөмж хүргүүлээ.

Орхон аймгийн Жаргалант сумын салбар хороог сайн ажилласан тул 20,762.9 мянган төгрөгийн 26 нэр төрлийн ногоо даршлах, савлах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг 2019 онд олгосноос хойш ашиглалтгүй байх тул Жаргалант сумын Засаг даргад сумын ногоочдыг дэмжиж ажиллах ажлын байрыг гэрээний дагуу ашиглуулж, жижиг дунд орлоготой бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллах талаар зөвлөмж хүргүүлээ.

Баян-Өндөр сумын Засаг дарга, Фермер эмэгтэйчүүдийн холбоо, Булган ус ХХК-ийн хооронд гуравласан гэрээгээр Яргуйт багийн хөтөлд жишиг гудамжинд Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөс 15,000.0 мянган төгрөг, төсөл хөтөлбөрөөс 12,000.0 мянган төгрөг, үр шим хүртэгчээс 500.0 мянган төгрөг нийт 27,500.0 мянган төгрөгөөр худаг гаргах, худгийн байшин барих ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан.

Гэрээнд зааснаар Яргуйт багийн хөтөлд 1 худаг барьж гүйцэтгэх ёстой боловч нэг гэрээгээр Яргуйт, Эрдэнэ багт 2 худгийн ажлыг гүйцэтгэж, нэг гэрээгээр 2 өөр байршилд ажил гүйцэтгэсэн.

Баян-Өндөр сумын ЗДТГ Орон нутгийн өмчийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 791 дүгээр албан бичгийг үндэслэн Яргуйт багт гүйцэтгэсэн худгийг 13,359.5 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгөд орлого авсан бол Эрдэнэт багт байрлах Ёс заншлын өргөөний гадаа хийгдсэн худгийн ажлыг санхүүгийн бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан байна. Гуравласан 19/08 тоот гэрээнд тусгагдсаны дагуу хөрөнгийг бүртгэх тухай албан шаардлага хүргүүлээ.



Эрдэнэ багт байрлах бүртгэлгүй худаг

Эрдмийт ХХК нь Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилтийн төслөөс Хаан банкаар дамжуулан 2,200.0 сая төгрөгийн 7 жилийн хугацаатай жилийн 8%-ийн хүүтэй зээлийг авч төслийг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд байгууллагын санхүүгийн тайланд төсөлтэй холбоотой 317.5 сая төгрөгийн барилга байгууламж, 334.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 29.3 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 113.4 сая төгрөгийн тавилга эд хогшил, 3.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийт 797.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.

Эрдэнэт мах маркет ХХК нь Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилтийн төслөөс Хаан банкаар дамжуулан 5,390.3 сая төгрөгийн 7 жилийн хугацаатай жилийн 8%-ийн хүүтэй зээл авч төслийг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд байгууллагын санхүүгийн тайланд төсөлтэй холбоотой 2,254.2 сая төгрөгөөр барилга байгууламж капиталжуулсан, 3,510.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж нийт 5,764.5 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.

## **ДҮГНЭЛТ:**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Орхон аймагт Засгийн газрын шугамаар олгогдсон зээлийн батлан даалтын сан болон БНБУ-ын хөнгөлөлттэй зээлээс ажлын байр нэмэгдээгүй.
- Хөдөө аж ахуйн зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжүүд зээлийн гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Бага орлоготой иргэн, аж ахуйн нэгжид зээл олгосноор ажлын байр нэмэгдээгүй байна.
- Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдаж байна.
- Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь урт, дунд, богино хугацааны бодлогыг дэмжиж байна.
- Тусламж нь нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан хөрөнгө оруулалт боловч ашиглалтгүй, үр өгөөжгүй хөрөнгө байсаар байна.
- Төслийг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг орон нутагт үнэлж дүгнэдэггүй.
- Засгийн газрын тогтоолд тусгагдсан төлөвлөх, зарцуулах, тайлагнах ажлууд орон нутагт хийгддэггүй.
- Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг үнэлсэн ч төсөлд оролцогч нарт мэдээлдэггүй.
- Зээл тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо орон нутагт үр нөлөөгүй байна.
- Төслийн явц, гүйцэтгэлд яам хяналт хэрэгжүүлдэг бол орон нутгийн байгууллагын оролцоо байхгүй.
- Шилэн дансны цахим сайтад зээл, тусламжтай холбоотой мэдээллийг мэдээлдэггүй.
- Хөрөнгийн ашиглалтын үр дүнг тооцож, төсөлд оролцогч нарыг мэдээллээр хангаагүй.
- ТХН-ээс жилд 1-2 удаа ирж хяналт хэрэгжүүлсэн ч үр дүнг тооцсон мэдээ, мэдээллээр төсөл хэрэгжүүлэгч нарыг хангаж ажиллаагүй.

Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж

- Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга, хэмжээний үр дүнд бий болсон эд хөрөнгийг зарим байгууллага бүртгэлд тусгаагүй.

**ЗӨВЛӨМЖ:**

**ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГАД:**

- Монгол ногоо хөтөлбөрийн хүрээнд Жаргалант сумын салбар хороонд өгсөн 20,762.9 мянган төгрөгийн ногоо даршлах, савлах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалтыг сайжруулж, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих талаар үр дүнтэй арга хэмжээ авах.

**20-Р ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, 2-Р ЦЭЦЭРЛЭГ, 22-Р ЦЭЦЭРЛЭГ, 26-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ НАРТ**


- Монгол ногоо төслөөс олгосон 1,270.0 мянган төгрөгийн хүлэмж болон бусад багаж хэрэгслийг хөрөнгийн бүртгэлд тусгах,

**САНАЛ: Үндэсний аудитын газарт.**


- Беларусь Улсын хөрөнгө оруулалтаар Орхон аймагт 33,920.0 еврогийн үнэтэй 4 тоног төхөөрөмж авсан 2 иргэн аж ахуйн нэгж зээлийн хугацаанд төлбөрөө бүрэн төлж байгаа ч төслийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу ашиглахгүй байх тул арга хэмжээ авах.
- Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд нь орон нутаг дахь байгууллагаар дамжихгүй байгаа нь мэдээлэл авах, хяналт хэрэгжүүлэх зэрэгт хүндрэл үүсгэж байгаа тул холбогдох орон нутгийн байгууллагуудыг мэдээллээр хангаж байх тухай удирдах байгууллагууд зөвлөмж хүргүүлэх.

**ТАЙЛАН БИЧСЭН:**

АХЛАХ АУДИТОР  Т.БОЛОРМАА

АУДИТОР  О.ГАНТУЯА

**ГҮЙЦЭТГЭСЭН:**

АУДИТОР  Ж.НАРАНЧИМЭГ

Холбогдох байгууллагын санал:



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА**


Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,  
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033  
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621  
Цахим шуудан: info@erdenet.mn

2023 08.16 № 02/1870  
танай -ны № -т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Ц.НАРМАНДАХ ТАНАА**

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн  
хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн  
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.  
Тус гүйцэтгэлийн тайланд саналгүй болно.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



А.ТҮВШИНЖАРГАЛ

6123021893



**ОРХОН АЙМАГ  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
ГАЗАР**

Залуучуудын гудамж, Зэст баг  
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61029

Утас/Факс: 7773 3153

Цахим шуудан: OrkhonHNAAG@gmail.com

2023.08.17 № 03/222


танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г

Г

**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд манай байгууллагаас өгөх санал байхгүй болно.

ДАРГА  Ж.БАТ-ӨЛЗИЙ



D:/Alban toot/ 2023 on /A-5/



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 129/А/1440338

Эрдэнэт

ОРА-2023/25-13-ШТА-ГА

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Яргуйт багийн хөтөлд хийгдсэн жишиг гудамжны худаг гаргах, худгийн байшин барих ажил хийгдэж Эрдэнэ багийн худгийн ажлыг хүлээн авч бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1-д “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргаа харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийн таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгөд бүртгээгүй худгийг бүртгэж, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын дарга Ш.Өлзийбаяр, Санхүүгийн албаны дарга Б.Ган-Эрдэнэ, Нягтлан бодогч А.Адъяадолжин нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР: ..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР: ..... Б.БУЯН-УНДРАХ

АХЛАХ  
АУДИТОР ..... Т.БОЛОРМАА

АУДИТОР ..... О.ГАНТУЯА

АУДИТОР ..... Ж.НАРАНЧИМЭГ